



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 497

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, 2022 оны 293 дугаар тогтоолын 3.4, 5.2 дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Худалдаа үйлдвэрийн их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн харьяалал өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 106,767,000.00 (нэг зуун зургаан сая долоон зуун жаран долоон мянган) төгрөгийн балансын үнэ, 30,750,112.70 (гучин сая долоон зуун тавин мянга нэг зуун арван хоёр төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгө, 51,451,657.81 (тавин нэгэн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга зургаан зуун тавин долоон төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Хөдөө аж ахуйн их сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баатарцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Худалдаа үйлдвэрийн их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн нэр дээрх 2947 м.кв талбай бүхий сургалтын зориулалттай газар эзэмших эрхийг Хөдөө аж ахуйн их сургуулийн нэр дээр шилжүүлэн баталгаажуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
100000/01

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 11 дүгээр сарын 19 өдрийн
19 дугаар тогтоолын хавсралт

**ХУДАЛДАА ҮЙЛДВЭРИЙН ИХ СУРГУУЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛИАС ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ /ш/	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Тайлбар
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2022.01.01	1	51,018,857.81	51,018,857.81	-	51,018,857.81	Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валют/
2	Бараа материал	2022.01.01	1	432,800.00	432,800.00	-	432,800.00	Хангамжийн материал
Эргэлтийн хөрөнгийн дүн					51,451,657.81	-	51,451,657.81	
3	Сургуулийн барилга	1966.07.05	1	28,896,000.00	28,896,000.00	28,896,000.00	-	Барилга
4	Газар эзэмших эрх /нэгж талбарын дугаар 6409007422/	2019.01.01	2947 м2	73,675,000.00	73,675,000.00	-	73,675,000.00	Газар
5	Принтер	2017.09.20	1	210,000.00	210,000.00	157,500.00	52,500.00	Тоног төхөөрөмж
6	Принтер /3 үйлдэлт/	2019.10.01	1	287,500.00	287,500.00	162,916.78	124,583.22	
7	Өнгөт принтер	2021.07.01	1	406,000.00	406,000.00	87,966.71	318,033.29	
8	Суурин компьютер	2021.07.01	1	1,000,000.00	1,000,000.00	216,666.71	783,333.29	
9	Ширээ сандал	2019.06.01	15	103,500.00	1,552,500.00	1,229,062.50	323,437.50	Тавилга эд хогшил
10	Ном	2022.04.01	20	200,000.00	740,000.00	-	740,000.00	Ном
Эргэлтийн бус хөрөнгийн дүн					106,767,000.00	30,750,112.70	76,016,887.30	
Нийт дүн					158,218,657.81	30,750,112.70	127,468,545.11	